**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 02 сарын 04 өдөр　　Дугаар А/23　　Чойр

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний
хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг шинээр болон өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг дор дурдсанаар баталсугай.

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар;/Урьд нь Байгаль орчны газар байсан/
- Биеийн тамир, спортын газар; /Урьд нь Соёл, спорт, аялал жуулчлалын газар байсан/
- Боловсрол, соёлын газар; /Урьд нь Боловсролын газар байсан/
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
- Мэргэжлийн хяналтын газар;
- Нийгмийн даатгалын хэлтэс;
- Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс;
- Онцгой байдлын хэлтэс;
- Санхүүгийн хяналт, аудитын алба;
- Статистикийн хэлтэс;
- Татварын хэлтэс;
- Тээвэр, авто замын газар;
- Ус, цаг уур, орчны шинжилгээний алба;
- Хөдөлмөрийн хэлтэс;
- Худалдан авах ажиллагааны алба;
- Хүнс, хөдөө аж ахуйн газар; /Урьд нь Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар/
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс;
- Цагдаагийн хэлтэс;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Эрүүл мэндийн газар;

2. Нэршилд нь өөрчлөлт орсон байгууллагууд бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн тогтоосон шийдвэр гарах хүртэлх хугацаанд хуучин тогтоосон бүтэц, орон тооны хүрээнд хуучин дүрмийг дагаж, мөрдөж ажиллахыг тухайн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Зарим агентлагийн бүтэц өөрчлөх тухай" А/132 дугаар захирамжийн 1 дүгээр заалт, 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/23 дугаар захирамжийн 1 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Л.ОДСЭР

D:\Ajil 2015\Zahiramj\Zahiramj A.docx

02 0074

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 02 өдөр Дугаар 69 Чойр

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", "ж", 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43,2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг нэгдүгээр хасралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

3. Дээрх хөтөлбөр батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 65 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.БАТЗАМ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 69 дугаар
тогтоолын 01 дугаар хавсралт

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

## Нэг. Ерөнхий мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулсан.

Өнөөгийн байдлаар манай аймагт Биеийн тамир, спортын газар, спортын мэргэжлийн холбоодын хүрээнд л биеийн тамир, спортын үйл ажиллагаа явагдаж байна.

Биеийн тамир, спортын газрын барилга нь 2004 онд хуучин хаягдал материал ашиглан чанар муутай баригдсан, даам, шатар, теннис зэрэг спортын төрлийн заал, танхим огт байхгүй, агааржуулалт байхгүй багтаамж бага, үзэгчдийн суудал маш цөөхөн байна. Мөн сагсан бөмбөг, волейбол, чөлөөт бөхийн хэрэглэл материалын хувьд хуучирсан байна.

Түүнчлэн 5-р сургууль дээр хөлбөмбөг, сагсан бөмбөгийн секц, Сансар хайрхан клуб дээр теннис, биллярдын секц, Шивээ-Овоо ХК-ын дэргэдэх “Хаялага” клубт бокс, жудо, сагсан бөмбөг, даам, модон бөмбөгийн секц, Шатрын холбооны дэргэд шатрын дугуйлан үйл ажиллагаагаа явуулж байна. Биеийн тамир, спортын газрын мэргэжилтнүүд дасгалжуулагчийн ажлыг давхар гүйцэтгэж байгаа нь сургалт дасгалжуулалтын ажилд сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө зардлыг шийдвэрлэдэг болсноор жилдээ 25-30 удаагийн бүс, улсын чанартай тэмцээнд оролцож чөлөөт бөх, жудо бөх, үндэсний бөх, ширээний теннис, волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөг, боксын төрөлд тогтмол медалийн төлөө өрсөлдөж, медаль хүртдэг болоод байна. Мөн усанд сэлэлт, хөнгөн атлетикийн төрлөөр 2016 онд улсын аваргын анхны медалиудаа аваад байна. Жилдээ орон нутагтаа 2-3 бүс, улсын чанартай тэмцээн зохион байгуулж, аймгаасаа төрөн гарсан алдартнуудын нэрэмжит тэмцээн, сагсан бөмбөг, волейболын лигүүдийг тогтмол зохион байгуулдаг болоод байна.

Хэдийгээр бүс, улсын хэмжээнд үзүүлэх амжилт тогтмол дээшилж байгаа ч цаашид уг амжилтаа бататгах, ганцаарчилсан төрлийн спорт ялангуяа тулааны спортын төрлүүд дээр амжилт буурсан нь эдгээрийг нэгдсэн бодлоготойгоор хөгжүүлэх шаардлага бий болгож байна.

Аймгийн хэмжээнд спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажиллагаа сайжирсан.

Засаг даргын нэрэмжит "Спортын бага наадам"-ыг зохион байгуулдаг болсноор байгууллага, хамт олноороо спортоор хичээллэгчийн тоо эрчимтэй нэмэгдэж байгаа тул спортын төрлийг нэмэгдүүлэн тогтмол зохион байгуулбал нийтийн биеийн тамирыг дэмжсэн бодлого болох юм.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго: Орон нутагт биеийн тамир, спортын мэргэжилтэн боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан, бүс, улс, олон улс, тив, дэлхийн тэмцээн уралдаанд амжилт үзүүлэх тамирчдыг бэлтгэн гаргах, иргэдийн эрүүл чийрэг амьдрах нөхцлийг бүрдүүлж, бие бялдрын хөгжилтийн түвшинг ахиулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.1.1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг бүхий л талаар дэмжин, хамтарч ажиллах

2.1.2. Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах

2.1.3. Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох, спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах

2.1.4. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах

## Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах

3.1.1. Биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн уралдаанд амжилттай оролцогчдыг урамшуулах

3.1.2. Биеийн тамир, спортын мэргэжлийн дасгалжуулагчид, чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид, дэмжигчидтэй хамтран ажиллах

3.1.3. Ганцаарчилсан төрлийн спортыг эрчимтэй хөгжүүлэх

3.1.4. Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулах

3.1.5. Өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд лигийн тэмцээнийг зохион байгуулах

3.2. Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах

3.2.1. Спортын сургалт дасгалжуулалтад ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангамж, хүрэлцээг сайжруулах

3.2.2. Орон сууцны хороолол, гэр хороолол, ажлын байрны орчимд биеийн тамирын талбай, чийрэгжүүлэлтийн танхим байгуулах хөдөлгөөнийг эрчимжүүлэн энэ чиглэлээр гадаад дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах

3.3. Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийг байгуулж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах

3.3.1. Өсвөрийн шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулалтыг эрчимжүүлэх

3.3.2. Өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах

3.3.3. Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох

3.3.4. Орон нутагтаа бүс, улсын чанартай тэмцээнийг тогтмол зохион байгуулах

3.3.5. Монголын бүх ард түмний спортын их наадам, Монголын үндэсний спортын их наадам, Монгол хүүхдийн спортын их наадмын анхан шатны тэмцээний орон нутагтаа зохион байгуулж бүсийн болон шигшээ тэмцээнд бэлтгэж оролцох

3.4. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах

3.4.1. Аймаг, сумдын Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ыг зохион байгуулах

3.4.2. Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх

3.4.3. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх

## Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

- Иргэдийн бие бялдар чийрэгжүүлэх 2-3 танхим, 2-3 талбайтай болсон байна.
- Ганцаарчилсан төрлөөр улсын аваргаас авах медалийн тоо 50-иас доошгүй хувиар нэмэгдсэн байна.

| № | Шалгуур үзүүлэлт | Одоогийн түвшин /2015 он/ | Хүрэх үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он |
| 1 | Биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоо /хүн амын эзлэх хувь/ | 1460 хүн 9.6% | 1600 хүн 10.8% | 1800 хүн 12% | 2200 хүн 15.8% | 2500 15.8% |
| 2 | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын хувь | 20% | 28.0% | 30.0% | 32.0% | 33.0% |
| 3 | Долоо хоногт 2-3 удаа 30 минутаас доошгүй хугацаагаар дунд зэргийн идэвхтэй хөдөлгөөнийг тогтмол хийдэг хүний эзлэх хувь | - | 23.6% | 25.6% | 27.0% | 28.6% |
| 4 | Спортын секц дугуйлангийн тоо | 15 | 16 | 17 | 19 | 20 |
| 5 | Спортын салбар холбоодын тоо | 15 | 17 | 18 | 19 | 19 |
| 6 | Спортын секц дугуйланд хичээллэгчдийн тоо | 650 | 700 | 750 | 800 | 850 |
| 7 | Спортын мэргэжилтэн багш дасгалжуулагчдын тоо /БТСГ, ЕБС, Коллеж, клубууд/ | 15 | 16 | 17 | 17 | 18 |
| 8 | Өсвөрийн шигшээ багийн спортын төрлийн тоо | 8 | 9 | 10 | 11 | 11 |
| 9 | Өсвөрийн шигшээ багт хичээллэгчдийн тоо /1-6 насны ангилалд/ | 127 | 130 | 135 | 150 | 170 |
| 10 | Орон нутагт зохион байгуулах бүс, улсын чанартай тэмцээний тоо | 2 | 4 | 6 | 8 | 8 |
| 11 | Бүс, улсын чанартай тэмцээн уралдаанаас авах медалийн тоо | 54 | 56 | 58 | 60 | 62 |
| 12 | Нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоо | 20 | 22 | 24 | 26 | 28 |

## Тав. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

5.1. Аймгийн Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг 2016-2020 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт нь даараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.2.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

5.2.2. Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хөрөнгө

5.2.3. Бусад эх үүсвэр

## Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээ

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Биеийн тамир, спортын газар, сумдын Засаг даргын Тамгын газар зохион байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

6.3. Аймгийн Засаг дарга жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 69 дугаар
тогтоолын 02 дугаар хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2017-2020/**

| Д/д | Үйл ажиллагаа | № | Бүтээгдэхүүн | Хэрэгжүү-лэх хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Санхүү -жилт | Хариуцах байгуул-лага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах | 1. | Биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн уралдаанд амжилттай оролцогчдыг урамшуулах | 2017-2020 | -Амжилт үзүүлсэн тамирчид, дасгалжуулагчдыг тухай бүр урамшуулна. | -100 хувь урамшуул-сан байна. | 18.0 АОНХС | АЗДТГ, БТСГ |
| | | 2. | Биеийн тамир, спортын мэргэжлийн дасгалжуулагчид, чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид, дэмжигчидтэй хамтран ажиллах | 2017-2020 | -Дэмжлэг туслалцаа тухай бүрт үзүүлсэн байна. | - | 4.0 АОНХС | АЗДТГ, БТСГ, БСУГ, сумдын ЗДТГ, сургуулиуд |
| | | 3. | Ганцаарчилсан төрлийн спортыг эрчимтэй хөгжүүлэх | 2017-2020 | -ганцаарчилсан төрлийн спортоор авах медалийн тооны өсөлт хувиар | -50-иас доошгүй хувиар өснө. | 12.0 АОНХС | БТСГ, БСУГ, сургуулиуд |
| | | 4. | Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 2017-2020 | -Зохион байгуулсан тэмцээний тоо | -6-аас доошгүй | 4.0 АОНХС | БТСГ, ТББ-ууд, иргэд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 5. | Өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд лигийн тэмцээнийг зохион байгуулах | 2017-2020 | -Зохион байгуулсан тэмцээний тоо | -5-аас доошгүй | 4.0 АОНХС | БТСГ, ТББ-ууд |
| 2. | Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах | 6. | Спортын сургалт дасгалжуулалтад ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангамж, хүрэлцээг сайжруулах | 2017-2020 | -Тоног төхөөрөмжөөр хангагдсан спортын төрлийн тоо | 3-4 төрөл | 100.0 УТХО | АЗДТГ, БТСГ, Төрийн болон ТББ-ууд |
| | | 7. | Орон сууцны хороолол, гэр хороолол, ажлын байрны орчимд биеийн тамирын талбай, чийрэгжүүлэлтийн танхим байгуулах хөдөлгөөнийг эрчимжүүлэн энэ чиглэлээр гадаад дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах | 2017-2020 | -Шинээр байгуулагдсан биеийн тамирын талбай, чийрэгжүүлэлтийн танхимын тоо | 2-оос доошгүй | СОНХС, Хувийн хэвш-лийн хөрөнгө | БТСГ, Сумдын ЗДТГ, Хувийн хэвшлийн хөрөнгө |
| 3. | | 8. | Өсвөрийн шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулалтыг эрчимжүүлэх | 2017-2020 | -Шигшээ багт хичээллэгчдийн тоо | -170 | - | БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |
| | | 9. | Өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах | 2017-2020 | -Жилдээ зохион байгуулах өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний тоо – Жилдээ зохион | - 7-оос доошгүй төрлөөр<br>-5-аас доошгүй | 15.0 АОНХС | БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний тоо | төрлөөр | | |
| | Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах | 10. | Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох | 2017-2020 | -Жилээ оролцох тэмцээний тоо | -20-оос доошгүй | 51.0 АОНХС | БТСГ , БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |
| | | 11. | Орон нутагтаа бүс, улсын чанартай тэмцээнийг тогтмол зохион байгуулах | 2017-2020 | Аймагт зохион байгуулах тэмцээний тоо | 8-аас доошгүй | 25.0 АОНХС | АЗДТГ, БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |
| | | 12. | Монголын бүх ард түмний спортын их наадам, Үндэсний спортын их наадам, Хүүхдийн спортын их наадмын анхан шатны тэмцээний орон нутагтаа зохион байгуулж бүсийн болон шигшээ тэмцээнд бэлтгэж амжилттай оролцох | 2017-2020 | -Наадмуудын анхан шатны тэмцээнийг тухай бүр зохион байгуулж, бүсийн болон шигшээ тэмцээнд оролцоно. | - | 20.0 АОНХС | АЗДТГ, БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд, сумдын ЗДТГ |
| | | 13. | Орон нутагт өвлийн спортыг тусгайлан хөгжүүлэх | 2017-2020 | -Шинээр хөгжүүлэх спортын төрлийн тоо | -2-оос доошгүй спорт хөгжиж эхэлсэн байна. | 2.0 АОНХС | БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд, сумдын ЗДТГ |
| | Орон нутагт нийтийн биеийн тамирын арга | 14. | Аймаг, сумдын Засаг даргын нэрэмжит "Спортын бага наадам"- | 2017-2020 | -Зохион байгуулах төрлийн тоо | -7-оос доошгүй | 12.0 АОНХС | АЗДТГ, БТСГ, сумдын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийн эрүүл чийрэг амьдрах нөхцлийг бүрдүүлэх | | ыг зохион байгуулах замаар иргэд спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх | | | | | ЗДТГ |
| 4. | | 15. | Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх | 2017-2020 | -Жилд зохион байгуулах арга хэмжээний тоо | -28-аас доошгүй | 9.0 АОНХС | БТСГ, сумдын ЗДТГ |
| | | 16. | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх | 2017-2020 | -сорилд хамрагдсан иргэдийн тоо хувиар | 33 хувь | - | БТСГ, Сумдын ЗДТГ, ТББ-ууд |
| **Хөтөлбөрийн хүрээнд 4 жилд зарцуулах хөрөнгө** | | | | | | | **176.0 АОНХС 100.0 УТХО** | |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/30 Чойр

“Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн задаргаа батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, 29.1.1.б, 29.1.5.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 10.1.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2016 оны 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Говьсүмбэр аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн задаргааг хавсралтын дагуу баталсугай.

2. Урамшуулалд шаардагдах 15 000 000 /Арван таван сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжил сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Н.Одонтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг цаг тухайд нь тайлагнаж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАТСУУРЬ

02 0088

Аймгийн Засаг даргын 2017 оны
01 сарын 31-ны өдрийн 1/20 дугаар
захирамжийн хавсралт

## "БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2017 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| № | Бүтээгдэхүүн | Зарцуулах хөрөнгө | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| 1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах | | | |
| 1 | Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 1 000 000 | БТСГ, ТББ-ууд, иргэд |
| 2. Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах | | | |
| 1 | Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох | 13 000 000 | БТСГ, БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |
| 3. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийн эрүүл чийрэг амьдрах нөхцлийг бүрдүүлэх | | | |
| 1 | Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх | 1 000 000 | БТСГ |
| | **Нийт зардал** | **15 000 000** | |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 10 өдөр Дугаар А/132 Чойр

"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд
хөтөлбөрийн төсвийн задаргаа батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, 29.1.5.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 10.1.7 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Говьсүмбэр аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн төсвийн задаргааг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 35 000 000 /Гучин таван сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Н.Одонтуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-т даалгасугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/30 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2017 оны
10 сарын 12-ны өдрийн 1/152 дугаар
Захирамжийн хавсралт

## “БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2017 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| № | Бүтээгдэхүүн | Зарцуулах хөрөнгө | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| 1. Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах | | | |
| 1 | Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 1 000 000 | АЗДТГ, БТСГ, ТББ-ууд, иргэд |
| 2. Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах | | | |
| 1 | Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох | 13 000 000 | БТСГ , БСУГ, сургуулиуд, ТББ-ууд |
| 2 | Орон нутагтаа бүс, улсын чанартай тэмцээнийг зохион байгуулах | 10 000 000 | АЗДТГ, БТСГ |
| 3. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийн эрүүл чийрэг амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | | | |
| 1 | Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх | 1 700 000 | АЗДТГ, БТСГ |
| 2 | Аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” зохион байгуулах | 9 300 000 | АЗДТГ, БТСГ |
| **Нийт зардал** | | **35 000 000** | |

**АЙМГИЙН "БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ"**

**ДЭД ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

2017.11.20 /2017 оны жилийн эцсийн байдлаар/

| "БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ | | | |
|---|---|---|---|
| **№** | **Агуулга, заалт** | **Үйл ажиллагаа, үр дүн** | **Хувь** |
| **Биеийн тамир, спортын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, баг, тамирчид, тэдгээрийн дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах** | | | |
| 1 | Биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн уралдаанд амжилттай оролцогчдыг урамшуулах. | Албан хаагчид, ажилчдын "Нийгмийн баталгаа хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулж төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.<br>-Спортын амжилт үзүүлсэн багш дасгалжуулагчдад цалингийн урамшуулал олгож хэвшсэн.<br>-"Оны шилдгийн шилдэг тамирчин", "Оны шилдэг тамирчин", "Оны шилдэг багш", Оны шилдэг танхим" зэргийг үзүүлсэн амжилт, хамт олноо манлайлсан байдал, зохион байгуулсан арга хэмжээ, хийсэн бүтээлч ажил зэрэгтэй уялдуулан шалгаруулдаг уг уралдаан оны эцэст дүгнэгдэнэ.<br>2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын тэмцээн уралдаанд амжилттай оролцсон баг тамирчдад Улсын цол, зэрэг олгох журмын дагуу тухай бүр цол, зэргийг олгож байна. 1-р зэрэг-22, 2-р зэрэг-36, 3-р зэрэг-16 тамирчин хүртсэн. Волейболын спортын дэд мастер-5, Волейболын спортын мастер-2, ОУХМ-6 зэрэг тамирчид цол зэрэг авсан. | 100 |
| 2 | Биеийн тамир, спортын мэргэжлийн дасгалжуулагчид, чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид, дэмжигчидтэй хамтран ажиллах. | МҮОХороо, МЧБХолбоо, МХАХолбоо, МВХолбоо, МГХолбоо, МҮСХолбоо, МҮБХолбоо, МЖБХолбоо, МШХолбоо, МОБХолбооноос зохион байгуулсан сургалт семинар, курс, онолын бага хурал, чуулганд 28 мэргэжилтэн багш дасгалжуулагчид хамрагдсан.<br>Аймгийн спортын салбар холбоодын тэргүүн болон дасгалжуулагч багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 2017 оны 02 сарын 17-нд зохион байгуулсан. Сургалтанд аймгийн 16 спортын салбар холбоод оролцсон. 2016 онд тэмцээн уралдаанд оролцсон байдал, цаашид хэрхэн анхаарч ажиллах талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн. Биеийн тамир, спортын газар салбар | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | холбоодуудын тэргүүнүүдтэй хамтын ажиллагаа, тэмцээн уралдаанд оролцох төсвийн зардлын гэрээг байгуулсан. | |
| 3 | Ганцаарчилсан төрлийн спортыг эрчимтэй хөгжүүлэх. | Ганцаарчилсан төрөл болох жүдо, чөлөөт бөхийн дасгалжуулагч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, секц, дугуйланг тогтмол зохион байгуулахыг үүрэг өгсөн. Мөн 2019 оны хүүхдийн их наадам оролцох насны хүүхдүүдийн судалгааг гаргуулан сургалт, дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, жил, улирал, сараар нь төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. | 90 |
| 4 | Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | Сагсан бөмбөгийн анхны спортын мастер У.Мөнхбаатарын нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээнийг 10 сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулж, эмэгтэй 6, эрэгтэй 15 багийн 230 гаруй тамирчирд оролцсон. Тэмцээний зардалд Улсын төсвөөс 1000,0 мян төгрөгийг зарцуулсан. | 100 |
| 5 | Өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд лигийн тэмцээнийг зохион байгуулах. | Өсвөрийн хүүхдүүдийн дунд "Бидний лиг-2017" тэмцээнийг 01 сарын 21-нээс 03 сарын 30-ны хооронд сагсан бөмбөгийн-8, волейболын-8 баг нийт 16 багийн 220 тамирчдын дунд зохион байгуулсан. Тэмцээний зардалд улсын төсвөөс-1000,0 мян төгрөгийг зарцуулсан.<br>Залуучуудын дунд "Хөгжлийн лиг-2017" тэмцээнийг 01 сараас 04 сарын 25-ныг хүртэл зохион байгуулж, нийт эр 8, эм 6, нийт 14 багийн 168 тамирчин өрсөлдөж шилдэгүүдээ тодруулсан. Аймгийн ЗДТГ-аас 1,5 сая төгрөг, Аймгийн сагсан бөмбөгийн холбооноос 7,5 сая төгрөг, нийт 9,0 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |
| **Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах** | | | |
| 6 | Спортын сургалт дасгалжуулалтад ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангамж, хүрэлцээг сайжруулах. | Биеийн тамир, спортын тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг сайжруулах үүднээс улсын төсвийн санхүүжилтээр 4883,0 мян төгрөгийн хэрэглэл материалыг аваад байна. /волейбол, сагс, ширээний теннисний бөмбөг/.Спортын дасгалжуулагч нарт хүлээлгэн өгсөн/. | 90 |
| 7 | Орон сууцны хороолол, гэр хороолол, ажлын байрны орчимд биеийн тамирын талбай, чийрэгжүүлэлтийн танхим байгуулах хөдөлгөөнийг эрчимжүүлэн энэ чиглэлээр гадаад дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах. | Улсын биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буй нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах улсын уралдааны төсөлд Аймгийн хэмжээнд "Дасгал-Хөдөлгөөн" төслийг хүргүүлсэн.<br>5-р сургуулийн сурагчдын дотуур байрны гадна тоглоомын талбайн засварын ажилд хамтран ажиллаж, элсийн волейболын талбайн хэмжээ, бусад чийрэгжүүлэлтийн тоглоомын талаар мэргэжлийн үүднээс зөвлөгөө өгсөн. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| **Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах** | | | |
| 8 | Өсвөрийн шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулалтыг эрчимжүүлэх | Өсвөрийн шигшээ багийг волейбол, чөлөөт бөх, жүдо бөх, хөнгөн атлетик, ширээний теннис, хөлбөмбөг, сагсан бөмбөг, бокс, усан спорт, шатрын төрлөөр байгуулсан. Өсвөрийн шигшээ баг спортын 10 төрлөөр улсын аварга шалгаруулах 16 тэмцээнд 1-6 насанд, Бүсийн чанартай 5 тэмцээнд оролцсон. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 4 төрлөөр 10-12 нас, 13-14 нас, 15-17 насны ангиллаар зохион байгуулсан. Улсын хэмжээний сургалт зөвлөгөөнд 12 спортын холбоод, 2 клуб, 5 секц дугуйлангийн нийт 13 багш дасгалжуулагчид оролцсон.<br>2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын аварга шалгаруулах болон урьдчилсан шатны тэмцээн уралдаанд спортын 11 төрлөөр Орон нутаг хөгжил сангаас-**22183,8** мян төгрөг, улсын төсвөөс-**18441,4** мян төгрөгийг зарцуулсан. Нийт 40625,2 мян төгрөгийг зарцуулсан.<br>Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутаг хөгжүүлэх сангаас 2017 онд тэмцээн, уралдаан, нийтийн биеийн тамирын зардалд 15,0 сая төгрөгийг баталсан. Нэмэлтээр 20,0 сая төгрөгийг баталсан. | 100 |
| 9 | Өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах. | 2017 оны жилийн эцсийн байдлаар өсвөрийн аймгийн аварга шалгаруулах спортын 4-н төрлийн тэмцээнийг зохион байгуулсан. Үүнд: Хөнгөн атлетик, шатар, Жүдо бөх, хөлбөмбөг, Зуун буудалт даам зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Спортын салбар холбоод шагналын зардалд -1200,0 мян төгрөг зарцуулсан.<br>Насанд хүрэгчдийн шагайн харваа, үндэсний сурын нэлттэй харваан, ширээний теннис, волейболын шалгаруулах зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Шагайн харваанд улсын төсвөөс-430,0 мян төгрөг, сурын нэлттэй харваанд Спортын салбар холбооноос 200,0 мян төгрөг, Волейболын тэмцээнд-1000,0 мян төгрөг улсын төсвөөс зарцуулсан. | 100 |
| 10 | Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох. | 2017 онд бүсийн тэмцээнээс 6 алт, 6 мөнгө, 16 хүрэл медаль нийт 28 медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 7 алт, 11 мөнгө, 28 хүрэл нийт 46 медаль, Олон улсын тэмцээнээс 2 алт, 1 мөнгө, 8 хүрэл медаль хүртсэн. Нийт 86 медаль авсан. 2016 онд жилийн эцсийн байдлаар 61 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | медаль авсан бол 2017 онд жилийн эцсийн байдлаар 86 медаль авч 29,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 11 | Орон нутагтаа бүс, улсын чанартай тэмцээнийг тогтмол зохион байгуулах | 2017 оны Футзалын хөвгүүдийн 15,17 насны ангиллын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олгох бүсийн тэмцээнийн 2017 оны 01 сарын 4-ноос 6-ны хүртэл Говьсүмбэр аймагт зохион байгуулагдлаа.Тэмцээнд Хэнтий аймаг, Дорноговь аймаг, Сүхбаатар аймаг, Дорнод аймаг, Говьсүмбэр аймаг гэсэн 5 аймгийн 8 багийн 90 гаруй тамирчид оролцлоо.<br>Монголын хөлбөмбөгийн холбооны идэрчүүдийн U-15, U-17 насны 2017 оны улсын аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шат болох зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 21-28-ны өдрүүдэд хөлбөмбөгийн талбайд зохион багйуулж, U-15 насны ангилалд 1-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг, 2-р байранд н.Гүн-урсгал дасгалжуулагчтай Дорноговь аймгийн баг тамирчид орсон. U-17 насны ангилалд 1-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг, 2-р байранд н.Гүн-урсгал дасгалжуулагчтай Дорноговь аймаг, 3-р байранд Ц.Өсөхбаяр дасгалжуулагчтай Сүхбаатар аймгийн баг тамирчид орсон. Говьсүмбэр аймгийн U-15, U-17 насны ангилалын баг тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.<br>Говийн бүсийн цагдаагийн байгууллагуудын аварга шалгаруулах Сагс, гар бөмбөгийн тэмцээн энэ сарын 9-11-ний өдрүүдэд Говьсүмбэр аймагт зохион байгуулсан. Тэмцээнд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар, мөн аймгийн Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчид оролцож, авхаалж, самбаагаа сорьсон.<br>Сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй төрлийн тэргүүн байрт Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтсийн баг, дэд байрт Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын баг, эмэгтэй төрөлд Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын баг тэргүүн байр, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын баг дэд байр эзэлжээ. Харин гар бөмбөгийн тэмцээний эрэгтэй, эмэгтэй төрөл тус бүрт Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын баг | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | тэргүүлж, Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын баг дэд байрт шалгарсан.<br>Хөдөөгийн багш нарын XV удаагийн “Спортын наадам” манай аймагт хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулагдсан. "Спортын наадам"-д Баянхонгор, Говь-Алтай, Дархан Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Хөв сгөл, Говьсүмбэр гэсэн 11 аймгийн 348 багш тамирчид спортын 5 төрлийн 108 багц медалийн төлөө өрсөлдсөн. Нэгдсэн дүнгээр тэргүүн байранд 33 оноогоор Орхон аймаг шалгарч Шилжин явах Цомын эзэд болсон бол хоёрдугаар байранд 48.5 оноогоор Сэлэнгэ аймаг, гуравдугаар байранд 54.5 оноогоор Дархан-Уул аймаг тус тус орсон.<br>2017 оны 11-р сарын 4-10-ны өдрүүдэд Говьсүмбэр аймагт волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 81-н багийн 90 багш дасгалжуулагч, 970 тамирчин оролцож, Говьсүмбэр аймгийн эмэгтэй баг тамирчид хүрэл медаль хүртсэн. | |
| 12 | Монголын бүх ард түмний спортын их наадам, Үндэсний спортын их наадам, Хүүхдийн спортын их наадмын анхан шатны тэмцээний орон нутагтаа зохион байгуулж бүсийн болон шигшээ тэмцээнд бэлтгэж амжилттай оролцох. | Политехник коллежийн оюутнууд спортын 2 төрлөөр аваргаа шалгаруулж, 360 /давхардсан тоогоор/ оюутан хамрагдан, 612,0 мян төгрөгийг зарцуулсан. | 90 |
| 13 | Орон нутагт өвлийн спортыг тусгайлан хөгжүүлэх. | Өвлийн спортыг хөгжүүлэх үүднээс 2016 онд 740,0 мян төгрөгийн үнэ бүхий чарга-4ш, тэшүүр-4ш хэрэглэл материал авсан.<br>Сүмбэр гарденийг баазыг ашиглан цана болон хоккей спортын анхан шатны сургалтыг 12 сараас эхлэн зохион байгуулахаар төлөвлөөд байна. | 70 |
| **4. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийн эрүүл чийрэг байх нөхцлийг бүрдүүлэх.** | | | |
| 14 | Аймаг, сумдын Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ыг зохион байгуулах замаар иргэд спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх. | “Спортын бага наадам”-ыг спортын 8 төрлөөр 05 сарын 01-14-ны хооронд амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 82 байгууллага нэгдэн 20 багийн 650 гаруй албан хаагч, ажилчид оролцож спортын 8-н төрлөөр өрсөлдлөө. Шинээр Нийтийн монгол бөх, мини хөлбөмбөг тэмцээнүүдийг зохион байгуулсан.<br>Ттэмцээнд оролцсон албан байгууллага хамт олон биеийн тамир, спортоор хичээллэх, байгууллагууд хооронд хамтран ажиллах, уялдаа холбоо сайжирсан. Байгууллагууд зохион байгуулалт сайтай, идэвхитэй оролцсон. | 100 |

| | | | |
| 2 | Ганцаарчилсан төрлийн спортыг эрчимтэй хөгжүүлэх. | Ганцаарчилсан төрөл болох жүдо, чөлөөт бөхийн дасгалжуулагч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, секц, дугуйланг тогтмол зохион байгуулахыг үүрэг өгсний дагуу бэлтгэл, сургуулилт төлөвлөгөөний дагуу явагдаж байна.Үүний хүрээнд өсвөрийн тамирчдын ур чадвар ахисан.<br>2019 оны хүүхдийн спортын их наадамд оролцох насны хүүхдүүдийн судалгааг гаргуулан сургалт, дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, жил, улирал, сараар нь төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>**Үр дүн**: Жүдо бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгө, хүрэл медаль хүртсэн. Самбо бөхийн хүрэл медаль, жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгө, хүрэл медаль хүртсэн. | 100 |
| 3 | | БТСГ-ын анхны дарга, Жүдо бөхийн анхны дасгалжуулагч С.Балжиннямын | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | Аймгаасаа төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | нэрэмжит Жүдо бөхийн аймгийн аварга шалгаруулх тэмцээн 2019 оны 02 сарын 23-ны амжилттай зохион байгууллагдсан. Тэмцээнд өсвөр үеийн 14 жин, насанд хүрэгчдийн 3-н жин нийт 17 жинд 6 багийн 100 гаруй тамирчид оролцлоо. Нэгдсэн дүнгээр 1-р байранд Л.Амаржаргал дасгалжуулагчтай Шивээговь сумын Хаялга спорт клубын баг тамирчид, 2-р байранд М.Батдэлгэр дасгалжуулагчтай БТСГазрын баг тамирчид, 3-р байранд Гантулга дасгалжуулагчтай Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын "Боржигон" дэвжээний баг тамирчид орсон.<br>Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Лувсандоржийн ЦЭДЭНСОДНОМ агсны нэрэмжит волейболын СУПЕР - 8 идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн Чойр хотноо 08 сарын 01-07-ны хооронд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 6 аймаг, 1 дүүргийн эмэгтэй 7, эрэгтэй 6, нийт 13 багийн 160 гаруй тамирчид оролцсон.<br>Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Лувсандоржийн ЦЭДЭНСОДНОМ агсны нэрэмжит волейболын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 10 сарын 26,27-нд зохион байгуулсан.<br>**Үр дүн**:Орон нутагт их спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ахмад үеийн багш нарыг сурталчилан таницуулах, залуу хойч үед өвлүүлэн үлдээх ач холбогдолтой байна. | |
| 4 | Өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд лигийн тэмцээнийг зохион байгуулах. | Өсвөрийн хүүхдүүдийн дунд волейболын "Бидний лиг-2019" тэмцээнийг 01 сарын 15-17-нд зохион байгуулж, эрэгтэй 6, эмэгтэй 6 нийт 12 багийн 110 тамирчин оролцсон. Улсын төсвөөс 500,0 мянга төгрөгний дэмжлэг үзүүлсэн.<br>Залуучуудын дунд волейболын чойр хөгжлийн DREAM ЛИГ – 2019 тэмцээн 2019 оны 02 дугаар сарын 23-наас 03 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулж, нийт эрэгтэй 5, эмэгтэй 8 багийн нийт 140 гаруй тамирчин өрсөлдөж шилдэгүүдээ тодруулсан. Нийт зардалд-5600,0 мянга төгрөг, Аймгийн волейболын холбооноос-1500,0 мянга төгрөг, Ивээн тэтгэгчээс 4000,0 мянга төгрөг дэмжлэг үзүүлсэн.<br>**Үр дүн**: Өсвөр, залуучууд тамирчдын ур чадвар ахиулан багийн сэтгэл зүй, хамтын ажилллагаа дараагийн бүс, улсын чанартай тэмцээнд оролцох тоглох сэтгэл зүй бүрдүүлэн туршлагажсан. | 100 |
| **Зорилт:2 Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах** | | | |
| 5 | Спортын сургалт дасгалжуулалтад ашиглах тоног | 2019 онд 01 сарын 10-нд Спортсан салбар холбооны хурлын үеэр Спортын холбоодод спортын хэрэглэл материалаар дэмжлэг үзүүлсэн. Нийт 3-н сумд болон 11 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | төхөөрөмж, хэрэглэл материалын хангамж, хүрэлцээг сайжруулах. | спорт холбоодод 5,8 сая төгрөгийн хэрэглэл материалыг олгосон.<br>Хүүхдийн спортын их наадмын шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдаа 150 ширхэг тамирын хувцас хангагдсан. Хөрөнгийг ОНХС-аас 9,0 сая төгрөгийг зарцуулсан.<br>**Үр дүн**: Жил бүр тодорхой хэмжээний спортын хэрэглэл, материалаар хангаж, хүрэлцээг нэмэгдүүлэн ажиллаж байна. | |
| 6 | Орон сууцны хороолол, гэр хороолол, ажлын байрны орчимд биеийн тамирын талбай, чийрэгжүүлэлтийн танхим байгуулах хөдөлгөөнийг эрчимжүүлэн энэ чиглэлээр гадаад дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах. | Монгол улсын Засгийн газрын дэмжлэгээр, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агенталгийн санхүүжилтээр "Нийгмийн эгэх хариуцлага" дэд төслийн хүрээнд "Эрүүл зүрх-Эрүүл хөдөлгөөн-Эрүүл ёс зүй" дэд төсөл нээлтээ хийсэн.<br>Төслийн хүрээнд Аймгийн засаг даргын 2019 оны 05 сарын 08-ны А/18/4 дугаар тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Өглөөний агаар-Идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт өглөөний гүйлт 2019 оны 05 сарын 09-ны өглөөний 07 цагаас "Сүмбэр гарден" амралт, соёлын хүрээлэнд эхлэн 09 сарын 05-ны байдлаар 89 удаагийн 439 байгууллагын давхардсан тоогоор 2589 албан хаагч, иргэн хамрагдаад байна. "Эрүүл хөдөлгөөн-60" өглөөний дасгалыг хөдөлгөөнд оролцох байгууллагуудыг хуваарилсны дагуу байгууллагууд идэвхтэй оролцуулсан. Албан байгууллагуудын дунд ажлын байранд хийх дасгалын тэмцээн зэрэг олон талт арга хэмжээг зохион байгууллаа.<br>**Үр дүн**: Иргэдийг бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэн халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж, хамтран ажиллаж хэвшиж байна. | 100 |
| **Зорилт:3 Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагаа эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах** | | | |
| 7 | Өсвөрийн шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулалтыг эрчимжүүлэх | Өсвөрийн шигшээ багийг волейбол, чөлөөт бөх, жудо бөх, хөнгөн атлетик, ширээний теннис, хөлбөмбөг, сагсан бөмбөг, бокс, усан спорт, шатрын төрлөөр байгуулсан. Өсвөрийн шигшээ баг спортын 10 төрлөөр улсын аварга шалгаруулах 16 тэмцээнд 1-6 насанд ангилалд, Бүсийн чанартай 12 тэмцээнд оролцсон. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын **10** төрлөөр 10-12 нас, 13-14 нас, 15-17 насны ангиллаар зохион байгуулсан. Улсын хэмжээний сургалт зөвлөгөөнд 12 спортын холбоод, 2 клуб, 5 секц дугуйлангийн нийт 18 багш дасгалжуулагчид оролцсон.<br>**"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх"** дэд хөтөлбөрийн хүрээнд улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 18 төрлийн 21 тэмцээнд оролцож, нийт 14487,0 мян төгрөг, хүүхдийн их наадамд спортын 13 төрлөөр 20495,5 мян төгрөг, бусад арга хэмжээнд **4602,0** мян төгрөг, 2019 оны жилийн эцсийн байдлаар **52,584,5** мян | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан.<br>**Үр дүн**: Өсвөрийн шигшээ багийн орон нутгийн онцлогт уялдуулан өсвөрийн шигшээ багийг бүрдүүлэн, бэлтгэл сургуулилтыг ахисан түвшинд барин бүс, улсын чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцож байна. | |
| 8 | Өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах. | 2019 оны жилийн эцсийн байдлаар өсвөрийн аймгийн аварга шалгаруулах спортын 7-н төрлийн тэмцээнийг зохион байгуулсан. Үүнд: Волейбол, Чөлөөт бөх, Хөнгөн атлетик, шатар, Жүдо бөх, Ширээний теннис, хөлбөмбөг, сагсан бөмбөг, Зуун буудалт даам зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Улсын төсөв болон Орон нутаг хөгжүүлэх сангаас нилээд 800,0 мян төгрөг, Спортын салбар холбоод шагналын зардалд -860,5 мян төгрөг нийт 1660,6 мян төрөг зарцуулсан.<br>Насанд хүрэгчдийн шагайн харваа, үндэсний сурын нээлт, отго харваа, суугаа волейбол, волейболын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Шагайн харваанд орон нутгийн хөгжүүлэх сангаас- 300,0 мян төгрөг, сурын нээлттэй харваанд Спортын салбар холбооноос 200,0 мян төгрөг зарцуулсан.<br>**Үр дүн:** Өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын салбар холбоод зохион байгуулснаар өсвөрий үе, насанд хүрэгчдийг спортоор хичээллүүлэн халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон спортоор нөхөрлөн өнгөрүүлж, хэвшээд байна. | 100 |
| 9 | Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох. | 2019 оны жилийн эцсийн байдлаар бүсийн тэмцээнээс 19 алт, 16 мөнгө, 43 хүрэл медаль нийт 88 медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 12 алт, 12 мөнгө, 28 хүрэл нийт 52 медаль, Олон улсын тэмцээнээс 1 мөнгө, 3 хүрэл медаль нийт 4 медаль хүртсэн. Нийт 140 медаль авсан.<br>2018 оны жилийн эцсийн байдлаар 116 медаль авсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 140 медаль авч 17,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>**Үр дүн**: Бүс, улс, олон улсын тэмцээнд орон нутгийн баг тамирчид амжилт үзүүлснээр орон нутгийг сурталчилах, олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц баг тамирчдын төрөн гаргах, залуу хойч үеийг бэлтгэлж байна. | 100 |
| 10 | Монголын бүх ард түмний спортын их наадам, Үндэсний спортын их наадам, Хүүхдийн спортын их наадмын анхан шатны тэмцээний орон нутагтаа зохион байгуулж бүсийн болон | Монголын хүүхдийн спортын VI их наадмын анхан шатны тэмцээнийг аймгийн засаг даргын 2019 оны 02 сарын 22-ны А/60 тоот хэмжээнд зохион байгуулах салбар комисс байгуулан аймгийн хэмжээнд 02 сарын 25-наас эхлэн 05 сарын 10-ныг хүртэл зохион байгуулсан. Спортын 15 төрлөөр оролцохоор баг тамирчдаа сонгон шалгаруулсан. Аймгаас шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд амжилттай баг тамирчид спортын 17 төрөлд 133 тамирчин, 17 дасгалжуулагч нийт 150 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 2 алт, 1 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | шигшээ тэмцээнд бэлтгэж амжилттай оролцох. | мөнгө, 6 хүрэл медаль хүртлээ.Тэмцээний зардалд улсын төсвөөс-3,2 сая төгрөг, ОНХС-аас 14,9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.<br>**Үр дүн**: баг тамирчдыг ур чадварыг ахиулах, чадварлаг баг тамирчдын төрөн гарах, түүхэн амжилтыг үзүүлэн ажилласан. | |
| **4. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийн эрүүл чийрэг байх нөхцлийг бүрдүүлэх.** | | | |
| 11 | Аймаг, сумдын Засаг даргын нэрэмжит "Спортын бага наадам"-ыг зохион байгуулах замаар иргэд спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх. | "Спортын бага наадам"-ыг спортын 8 төрлөөр 04 сарын 26-наас 05 сарын 05-ны хооронд амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 92 байгууллага нэгдэн 21 багийн 1300 гаруй албан хаагч, ажилчид оролцож спортын 8-н төрлөөр өрсөлдсөн. 1-р байранд Б.Төгсбаяр дарга Ганзам баг, 2-р байранд Х.Болатхан ахлагчтай Бизнес хөгжлийн баг, 3-р байранд Ц:Энхтүвшин дарга Шивээ-Овоо ХК-ний баг тамирчдад шалгарсан.<br>**Үр дүн**: 2 жилдээ 1 удаа зохион байгуулж хэвшсэн. Тэмцээнд оролцсон албан байгууллага хамт олон биеийн тамир, спортоор хичээллэх, байгууллагууд хооронд хамтран ажиллах, уялдаа холбоо сайжирсан. Байгууллагууд зохион байгуулалт сайтай, идэвхитэй оролцсон. | 100 |
| 12 | Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх. | 2019 оны жилийн эцсийн байдлаар нийтийн биеийн тамирын 30 арга хэмжээнд 5859 иргэн, усан спортын сургалтын төвөөр – 854 иргэнд хамрагдсан. Нийт 30 арга хэмжээнд 6713 иргэн /давхардсан тоогоор/ хамрагдсан.<br>2018 онд нийтийн биеийн тамирын 27 арга хэмжээнд нийт 4294 иргэн хамрагдсан бол 2019 онд 30 арга хэмжээнд 6713 иргэн хамрагдснаар 36,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>**Үр дүн**: Иргэдийг бие бялдрын хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тухай цаг үед тохирсон тэмцээн уралдаан, өдөрлөгийг зохион байгуулж, спортын заал, танхимаар тогтмол үйлчилж, холбоотой байгууллагатай хамтран ажиллаж туршлага хурамтуулан ажилласан. | 100 |
| 13 | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх | Ажилтан албан хаагч, арга зүйчид байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх биеийн тамирын арга хэмжээг оновчтой үр дүнтэй зохион байгуулж, зарим байгууллагын санаачлагаар ажлын байранд очиж сорил авсан.<br>Хавар, намрын сорилын ажиллагаанд 3 сум, 28 байгууллага, 1,2,3-р сургуулийн сурагч, нийт 2898 иргэнээс сорил авсан. Авсан сорилоо программд шивж байна.<br>2018 онд 2864 иргэн хамрагдсанаас 2019 онд 2898 иргэн хамрагдаж 0,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. А, В ээлэх хувь 55,6 хувьтай байна.<br>**Үр дүн**: Иргэн бүр бие бялдрын чийрэгжилтийг түвшингээ тогтоож, дутагдалтай иргэнд | 40 |

| | | | |
|---|---|---|---|
| | | хэрхэн өөрийгөө хөгжүүлж, өв тэгш бие бялдартай иргэн болох талаар мэдээлэл мэдлэгийг олж авч байна. | |

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

| Зорилт | Арга хэмжээний тоо | Үүнээс | | | | Үнэлэх боломжгүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 биелсэн | Хэрэгжих шатандаа | | | | |
| | | | 70% | 40% | 0% | | |
| Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ | 13 | 12 | - | 1 | - | - | 95,3 |

ТАЙЛАНГ ГАРГАСАН: БТСБХЗАлбаны дарга М.Батдэлгэр

ТАЙЛАНГ ХЯНАСАН:БТСГ-ын Даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Буянтогтох

Говьсүмбэр аймгийн Бүс, улс, Олон улсын тэмцээнээс медаль авсан байдал












ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр Дугаар А/81 Чойр

"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх"
дэд хөтөлбөрийн төсвийн задаргаа батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1а, 29.1.5а, 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 10.1.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2019 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 15 дугаар хуралдааны 09 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан Говьсүмбэр аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн задаргааг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 70000,0 /далан сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /А.Отгонтуяа /-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулан үр дүнг цаг тухайд нь тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга / Д.Содном /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2019 оны ..... дүгээр сарын .....-ний өдрийн .... дугаар захирамжийн ..... дугаар хавсралт

"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийн задаргаа

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Санхүүжилт / мян,төг/ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|
| **1.Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оролцох тэмцээн уралдааныг тоог нэмэгдүүлэн бүс, улс, олон улсын тэмцээнд оролцох спортын өндөр ур чадвартай тамирчдыг төрүүлэн гаргах.** | | | | | | |
| 1 | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн 13 төрлийн шигшээ багийн тамирчид болон залуучууд насанд хүрэгчдийн шигшээ баг тэмцээн уралдаанд оролцох, орон нутагт зохион байгуулах | 1.Бүс, улсын чанартай тэмцээн уралдаанд төлөвлөгөө хуваарийн дагуу оролцоно. | 34000,0 | Спортын сургалт дасгалжуулалтын түвшин дээшилнэ. Тамирчдын амжилт ур чадвар ахисан байна. | 1,2,3,4-р улирал | БТСГ<br>Спортын салбар холбоод |
| | | **1.1.Волейбол** Насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах. | 1000,0 | Хамрах хүрээ тэлж баг тамирчдын ур чадвар ахисан байна. | 11-р сард | БТСГ<br>АВХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 2000,0 | Медальт болон шагналт байрт шалгарсан байна. | 9-р сарын<br>14-20 | БТСГ |
| | | Идэрчүүдийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 2000,0 | Шигшээ тэмцээний эрх авсан байна. | 3-р сарын<br>11-14<br>/төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **1.2.Сагсан бөмбөг** Насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах. | 1000,0 | Зохион байгуулалтын арга хэлбэр дээшилсэн хамрах хүрээ тэлсэн байна. | 5-р сард | БТСГ АСБХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 1500,0 | Медальт болон шагналт байрт шалгарсан байна. | 4-р сард | БТСГ |
| | | Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыгоролцуулах | 1500,0 | Медальт болон шагналт байрт шалгарна. | 3-р сарын 23-29 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |
| | | **1.3.Жүдо бөх** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах. | 500,0 | Хичээллэгч хүүхдийн тоо өсөж, барилдааны ур чадвар дээшилсэн байна. | 4-р сард | БТСГ АЖБ Холбоо |
| | | Өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 700,0 | Шигшээ тэмцээнд оролцох эрхээ 60% нь хангана. | 5-р сарын 25-27 | БТСГ |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдын оролцуулах. | 700,0 | Медальт болон шагналт байрт шалгарна. | 6-р сарын /05-07 | БТСГ |
| | | **1.4.Шатар** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 500,0 | Шатар сонирхогч хичээллэгчдийн тоо өсөж, ур чадвар ахисан байна. | 4-р сард | БТСГ АШХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах | 750,0 | Шагналт болон медальт байрт шалгарна. | 3-р сарын 23-29 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бага насны улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах | 750,0 | Шагналт болон медальт байрт шалгарна. | 5-р сард | БТСГ |
| | | **1.5.Ширээний теннис** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 500,0 | Тамирчдын ур чадвар өсөж, хүрээ тэлсэн байна. | 4-н сард | БТСГ АШТХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах | 750,0 | Медальт болон шагналт байрт шалгарна. | 3-р сарын 18-21 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |
| | | Өсвөр үеийн лигийн аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах | 750,0 | Медальт болон шагналт байрт шалгарна. | 5-н сард | БТСГ |
| | | **1.6.Чөлөөт бөх** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 500,0 | Хичээллэгчдийн хүрээ тэлж ур чадвар өссөн байна. | 3-р сарын 22-23 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ АЧБХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 600,0 | Шагналт байрт шалгарна. | 4-р сарын 16-19 | БТСГ |
| | | А.Энхээгийн нэрэмжит Олон улсын тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 600,0 | Шагналт байрт шалгарна. | 5-р сарын 07-10 | БТСГ |
| | | **1.7.Хөлбөмбөг** Залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 1000,0 | Сонирхогч хичээллэгчдийн хүрээ тэлсэн багийн тоо нэмэгдсэн байна. | 5-р сард | БТСГ АХБХолбоо |
| | | Өсвөр үеийн зүүн бүсийн | 1500,0 | Шигшээ тэмцээний | 4-р сарын | БТСГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | | эрхээ авсан байна. | 23-29 | |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 1500,0 | Хасагдах шатанд шалгарна. | 5-р сарын 23-30 | БТСГ |
| | | **1.8.Даам** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 500,0 | Сонирхогч , хичээллэгчдийн хүрээ тэлсэн байна. | 3-р сарын 14-15 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ АДХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 600,0 | Шагналт болон медальт байрт шалгарна. | 4-р сарын 01-05 | БТСГ |
| | | Өсвөр үеийн олон хотын тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 600,0 | | 5-р сард | БТСГ |
| | | **1.9.Бокс** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын зардал | 750,0 | Шагналт болон медальт байрт шалгарна. | 3-р сарын 16-21 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ АБХолбоо |
| | | Бага насны улсын аварга шалгаруулах "Олимпийн гараа" тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 750,0 | | 6-р сарын 16-21 | БТСГ |
| | | **1.10.Хөнгөн атлетик** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 500,0 | Цар хүрээ тэлж хувийн амжилтууд өссөн байна. | 4-р сарын 04-05 | БТСГ АХАХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд | 600,0 | Шагналт болон медальт байрт | 4-р сарын 18- | БТСГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тамирчдыг оролцуулах. | | шалгарна. | 19 | |
| | | Олон төрөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 600,0 | | 5-н сар | БТСГ |
| | | **1.10.Футзал** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 600,0 | Сонирхогч, хүүхдийн тоо өсөж, ур чадвар, багийн тоглолт сайжирсан байна. | 11-р сарын /07-08 | БТСГ АХБХолбоо |
| | | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 1250,0 | Хэсгээсээ шалгарч 16/1 шигшээд тоглоно. | 3-р сарын 09-15 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |
| | | Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 1250,0 | | 11-р сарын 16-22 | БТСГ |
| | | **1.11.Усан спорт** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын зардал. | 600,0 | Тамирчдын ур чадвар, хувийн амжилт дээшилж, шагналт болон медальт байрт шалгарна. | 4-р сарын 11-13 | БТСГ |
| | | МУСХ-ы ерөнхийлөгчийн нэрэмжит тэмцээнд тамирчдыг оролцуулах | 600,0 | | 10-р сарын 02-04 | БТСГ |
| | | **1.12.Крикет** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцулах . | 1100,0 | Медальт байрт шалгарна. | 6-р сарын 24-27 | БТСГ |
| | | **1.13.Олс таталт** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг | 800,0 | Багийн зохион байгуулалт ур | 4-р сард | БТСГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | оролцуулах. | | чадвар өснө. | | |
| | | **1.14.Самбо барилдаан** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 700,0 | Шагналт болон медальт байрт шалгарна. | 3-р сарын 20-22 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ |
| | | **1.15.Пауэрлифтинг** Насанд хүрэгчид, залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах | 500,0 | Хичээллэгч сонирхогчдын хүрээ тэлж хувийн амжилтууд өснө. | 3-р сарын 07 /төлөвлөсөн тодорхойгүй/ | БТСГ АПХолбоо |
| | | **1.16.Спининг** аэробек аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 500,0 | Шинэ иөрлийн спорт хөгжих суурь тавигдана. | 10-р сард | БТСГ Спининг клуб |
| | | **1.17.Параспорт** аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 300,0 | ХБИ-ийн идэвх оролцоо дээшилнэ. | 4-р сарын 04 | БТСГ АХБИ Холбоо |
| | | **1.18.** Параспортын улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах. | 300,0 | Хувийн амжилт ахина. | 5-р сард | БТСГ |
| 2 | **Орон нутагт зохион байгуулах бүс, улсын чанартай тэмцээн, уралдаан** | Уралдаан тэмцээнийг өндөр хэмжээнд зохион байгуулсан байна. | **6000,0** | Улсын чанартай тэмцээн зохион байгуулж, туршлага арга хэлбэр дээшилж шинэчилэгдсэн байна. | 2,3 -р удирад | АЗДТГ, БТСГ, Спортын холбоод |
| | | 2.1.Үндэсний сурын Багийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах, зохион байгуулалтын зардалд | 2000,0 | Орон нутагтаа их спортыг сурталчлах, зохион байгуулах | 7-р сард | АЗДТГ БТСГ АҮСХолбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэг үзүүлэх | | арга туршлага нэмэгдэж, сонирхогч хичээллэгчдийн тоо өссөн байна. | | |
| | | 2.2.Жудо бөхийн өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, зохион байгуулалтын зардалд дэмжлэг үзүүлэх /медаль, өргөмжлөл гэх мэт/ | 2000,0 | | 5-р сарын 24-26 | АЗДТГ БТСГ АЖБХолбоо |
| | | 2.3.Боксын өсвөр үеийн / Улсын / тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, зохион байгуулалтын зардалд дэмжлэг үзүүлэн /медаль, өргөмжлөл гэх мэт/ | 2000,0 | | 8-р сард | АЗДТГ БТСГ АБХолбоо |
| **2. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулах замаар иргэдийг эрүүл чийрэг амьдрах нөхцлийг бүрдүүлэх** | | | | | | |
| 3. | Олон нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээний тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулан хамрах хүрээг өсгөх / Засгийн газрын 05-р тогтоолын хэрэгжилт / | Уламжлалт болон цаг үеийн холбогдолтой нийтийг хамарсан өдөрлөгүүд зохион байгуулсан байна. | **6700,0** | Идэвхтэй хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэлбэр сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Иргэд, хамт олны багийн зохион байгуулалт сайжирна. | 1,2,3-р улиралд | АЗДТГ, БТСГ |
| | | 3.1."Өвлийн агаар-Өлчир бие" өвлийн өдөрлөг | 1200,0 | | 12-р сарын 05 | |
| | | 3.2."Эх байгалиа хайрлан идэвхтэй амьдарцгаая" явган аялал | 800,0 | | 5-р сарын 02 | |
| | | 3.3."Хөдөөгийн баясгалан" хөдөөгийн залуучуудын өдөрлөг | 600,0 | | 8-р сард | |
| | | 3.4.Усан спортын "Усаар | 500,0 | | 9-р сарын | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чийрэгжье" акуа өдөрлөг | | | 05 | |
| | | 3.5.Ажлын байранд хийх дасгалын өдөрлөг, 30Х30 /30 өдөр 30 минут/ сарын аян зохион байгуулах. | 1600,0 | | 3,11-р сард | |
| | | 3.7.Өртөөт марафон | 2000,0 | | 5-р сард | |
| 4. | Үндэсний спортын төрөл | Орон нутагтаа тэмцээн уралдаан арга хэмжээ зохион байгуулан улсын чанартай тэмцээнд тамирчдыг оролцуулсон байна. | **6500,0** | Үндэсний спорт сонирхогч, хичээллэгчдийн тоо өсөж тамирчдын хувийн ур чадвар, амжилт дээшилсэн байна.<br>Багийн ажиллагаа сайжирна. | 1,2,3,4-р улиралд | АЗДТГ, БТСГ |
| | | **4.1.Үндэсний бөх** Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг зохион байгуулах. | 500,0 | | 5-р сарын 09-10 | |
| | | Өсвөр залуучуудын улсын аварга шалгаруулах барилдаанд тамирчдыг оролцуулах. | 800,0 | | 9-р сард | |
| | | Аймгийн баяр наадмын бөхийн цугларалт | 1200,0 | | 6-р сард 20-30 | АЗДТГ, БТСГ |
| | | **4.2.Үндэсний сурын харваа** Нээлтийн харвааг зохион байгуулах. | 500,0 | | 5-р сард 02-03 | |
| | | Улсын аварга шалгаруулах тэмцээнд харваачдыг оролцуулах. | 750,0 | | 6-р сарын 26-28 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Говийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд сурын харваачдыг хамруулах. | 750,0 | | 7-р сард | |
| | | **4.3.Шагайн харваа** Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах. | 500,0 | | 4-р сарын 18-19 | |
| | | Улсын аварга шалгаруулах тэмцээнд тамирчдыг оролцуулах | 750,0 | | 5-р сарын 06-10 | |
| | | Монгол бахархалын өдрийн тэмцээнийг зохион байгуулах | 750,0 | | 11-р сард | |
| 5. | Спортын алдарнуудыг алдаршуулах тэмцээн | Спортын алдартнуудыг алдаршуулах. | 2 500,0 | Спортын алдартнууд, түүхийг бүтээгчдээ алдаршуулах, сурталчлах, хүүхэд залуусыг спортод дуртай болгон хүмүүжүүлэх | 4-р улиралд | АЗДТГ, БТСГ Спортын салбар холбоод |
| | | С.Балжинням багшийн нэрэмжит чөлөөт бөхийн өсвөр үеийн тэмцээнийг зохион байгуулах. | 1000,0 | | 4-р сард | |
| | | ОУХ-ний мастер У.Мөнхбаатарын нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээний арга хэмжээг зохион байгуулах | 1500,0 | | 11-р сард | |
| 6 | Хүүхэд залуучуудын лигийн тэмцээн зохион байгуулах | Хүүхэд залуучуудын хөгжлийн түвшинг ахиулах лигийн тэмцээнүүдийг зохион байгуулах. | 3000,0 | Төрөл бүрийн лигийн тэмцээнийг тогмолжуулж тамирчдын ур яадвар тэмцээний туршлагыг | 2,3-р улиралд | БТСГ, Спортын салбар холбоод |
| | | 6.1.Хүүхдийн спортын “Бидний мөрөөдөл” лигийн тэмцээн | 1000,0 | | 1,4-р сард | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | /Сагсан бөмбөг ба Волейболын спортын 2 төрлөөр/ | | баяжуулан багийн зохион байгуулалтыг дээшлүүлсэн байна. | | |
| | | 6.2.Сагсан бөмбөгийн хөгжлийн "Чойр лиг" тэмцээнийг зохион байгуулах | 1000,0 | | 5-р сард | |
| | | 6.3.Волейболын залуучуудын "Мөрөөдөл" лигийн тэмцээнийг зохион байгуулах | 1000,0 | | 4-р сард | |
| 7 | Иргэдийн спортын II наадам | Иргэдэд чиглэсэн үйлчилгээг дээшлүүлж хөдөлмөр эрхэлдэггүй иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ТББ-ынхныг өргөн хамруулсан арга хэмжээ зохион байгуулах. | 6 000 0 | Нийгмийн бүх давхаргын иргэд хамрагдаж багаар ажиллах, өөрийгөө нээх боломж бүрдсэн байна. | 3-р улиралд | АЗДТГ, БТСГ Сумдын ЗДТГ |
| | | Спортын 5 төрлөөр аймгийн хэмжээний засаг захиргааны 10 багийн иргэдийн дунд явагдах "Иргэдийн спортын наадам" –ыг зохион байгуулах. | 6000,0 | | 9-р сарын 14-20 | |
| 8 | Гадаадын тэмцээн уралдаанд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх | Улсын шигшээ багийн өмнөөс гадаадад явагдах тэмцээнд оролцох тамирчдыг дэмжинэ. | 1500, 0 | Аливаа төлөвлөгдөөгүй цаг үеийн асуудал шийдэгдсэн байна. | Жилдээ | АЗДТГ |
| 9 | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэх | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд ТББ-аар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, үр дүнг аймгийн Засаг даргын | 500,0 | Гүйцэтгэлийн хувь | 9-р сард | ХШҮДАХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөлийнхурлаар хэлэлцүүлэх | | | | |
| **4. Зүүн бүсийн Биеийн тамир, спортын газруудын чуулга, уулзалт, зөвлөгөөн** | | | | | | |
| 10. | Зүүн бүсийн БТСГ-ын чуулга уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах | Чуулга уулзалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна. | 3300,0 | Удирдах мэргэжлийн байгууллагад орон нутгийн бодит нөхцөл байдлыг таниулан бүс нутгийн хамтын ажиллагаа бэхжсэн байна. | 2-р улиралд | АЗДТГ, БТСГ |
| Нийт 4 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ | | | | | | |
| **Нийт зардал** | | | **70000,0** | | | |

**Тайлбар:**Бүсийн болон улсын аварга шалгаруулах тэмцээний 2020 оны календарьчилсан төлөвлөгөө 2019 оны 12-р сард батлагдсан ба орон даяар хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон тул дээрх хуваарьт бүс, улсын аварга шалгаруулах тэмцээний сар, өдрийг тусгах боломжгүйг харгалзан батлагдсан хугацааг оруулав.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 22 өдөр Дугаар А/404 Чойр

Баг, тамирчид дасгалжуулагчдыг урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийн 8.1.3, дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Дэлхий, тив, улсын зэрэглэлтэй тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам", 2016 оны 69 дугаар тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" дэд хөтөлбөр, 2019 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай " тогтоол, 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/193 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 19–ны өдрийн 9 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээн, уралдаанд амжилттай оролцож медаль хүртсэн баг, тамирчин, дасгалжуулагчдад олгох урамшууллын хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Урамшуулалд шаардагдах 2 400 000 /хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 3 765 000 /Гурван сая долоон зуун жаран таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2020
оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 1404 дугаар
захирамжийн хавсралт

## Амжилт үзүүлсэн дасгалжуулагчдыг урамшуулах үйл ажиллагааны зардлын төсөв

| № | Зардлын төрөл | Ангилал | Төрөл | Тоо ширхэг | Нэгж үнэ | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгөн шагнал | Ганцаарчилсан спортын УАШТ | Тамирчин | - | - | 3900,0 |
| 2 | | | Дасгалжуулагч | - | - | 1600,0 |
| 3 | | Багийн спорт болон багийн төрлийн ангилалын УАШТ | Тамирчин | - | - | 350,0 |
| 4 | | | Дасгалжуулагч | - | - | 175,0 |
| 5 | Өргөмжлөл | | | 14 | 10,0 | 140,0 |
| Нийт дүн: | | | | | | 6165,0 |